

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын дугаар:** АЕГ/201902011

Архивын ерөнхий газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос “**Мэдээлэл технологийн үйлчилгээ**”-г нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2018 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ.

Тендерийн хамт 550000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

- 1 "Лицензтэй программ хангамж нийлүүлэх" 135,000 дүнтэй тендерийн баталгаа;
- 2 "Мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх төхөөрөмж нийлүүлэх" 335,000 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх;
- 3 "Архивын ерөнхий газрын [www.archives.gov.mn](http://www.archives.gov.mn) цахим хуудсыг шинэчлэх" 80,000 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх:** Эрхгүй

**Дотоодын давуу эрх тооцох эсэх:** Тооцохгүй

**Хугацаа:** Үнийн саналыг 2019 оны 03-р сарын 29-ний өдрийн 10:00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хуудсаар ирүүлнэ.

**Тендерийн шийдвэрлэлт:** Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 10:30 цагт Архивын ерөнхий газрын 4 давхарт 407 тоот өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) болон доорх хаягаар авч болно.

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Яармагийн дэнж, Буянт-Ухаа II хорооллын урд, Архивын ерөнхий газар.

*Архивын ерөнхий газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Ч.Оюунчимэг /77002085/*

**АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**